



# МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

---

ДУГААР 14



# ШҮҮХИЙН АКАДЕМИ

## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

**5,6,7  
САР**

2024.07.30 - Дугаар/15/



### ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА, МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН ШҮҮХИЙН АКАДЕМИ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЛЭЭ

Монгол Улсын Их хурлын 2024 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн ээлжит чуулганаар Шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн бөгөөд энэ үеэр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн эрх зүйн байдал, тогтолцоог гадаад улсуудын ижил чиг үүрэг бүхий шүүхийн сургалтын байгууллагын тогтолцоонд нийцүүлэн өөрчлөн байгуулах талаар хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тус Хүрээлэнг Шүүхийн Академи болгон өөрчлөн зохион байгуулахаар дэмжин баталсан юм. Монгол Улсын шүүхийн тухай хуульд оруулсан энэхүү нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын шүүхийн тухай хуульд оруулсан энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөхөөр тусгасны дагуу энэ өдрөөс эхлэн Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Шүүхийн Академи болж ажиллах журмаа Шүүхийн тухай хуульд нийцүүлэн шинэчлэн баталлаа.

### "ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ, ЭДИЙН БУС ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ТУЛГАМДСАН АСУУДАЛ" СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Олон улсын санхүүгийн корпорац (IFC)-тай хамтран иргэний хэргийн шүүхийн шүүгчдэд зориулсан мэргэшүүлэх сургалтыг "Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны тулгамдсан асуудал" сэдвийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтын нээлттэд тус Хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг болон Олон улсын санхүүгийн корпорацын Монгол дахь суурин төлөөлөгч Руфат Алимарданов нар үг хэлж, Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимиын тэргүүн Г.Алтанчимэг сургалтыг дүгнэж, хөдлөх эд хөрөнгийн барьцааны онцлог зохицуулалт, хөдлөх эд хөрөнгийг барьцаат хэллэлэр эдийн засгийн эргэлттэд оруулахын ач холбогдолын талаар онцлон тэмдэглэж, сургагч багш наарт талархал илэрхийллээ.

Энэ удаагийн сургалтыг Канад улсын Торонто хотын "Osgoode Hall" хуулийн сургуулийн профессор, Дэлхийн банкны бүлгийн зөвлөх Том Жонсон, Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа нар удирдан явууллаа. Энэ удаагийн сургалтад иргэний хэргийн шүүхийн нийт 52 шүүгч хамрагдлаа.

### "ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХАНДЛАГА" СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимиын шүүгч Б.Батцэрэн "Хувь хүний хөгжил, харилцаа хандлага" сэдвээр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн алба хаагчдад зориулсан дотоод сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр удирдан явуулав. Шүүгч-сургагч багш Б.Батцэрэн хуульч хүний эрхэмлэх үнэт зүйл болоод ёс зүй, харилцаа хандлага, оршихуйн эрхэм зорилго, аз жаргалын талаар мэдрэмж гээд хувь хүний хөгжил руу чиглэсэн олон талын жишээ тайлбараар баялаг сургалтыг удирдан, харилцан яриа өрнүүллээ.

**LIKE US ON FACEBOOK:**  
ШҮҮХИЙН АКАДЕМИ



[www.jtri.mn](http://www.jtri.mn)

**LINKED IN:**  
JUDICIAL ACADEMY OF MONGOLIA



## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

Дугаар/14/

### СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛЛОО

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн Сургалтын хөтөлбөрийн хорооны ээлжит хуралдаан 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр боллоо.

Энэ удаагийн хуралдаанаар эрүүгийн эрх зүйн чиглэлээр зохион байгуулах "Авлигын гэмт хэргийн эрх зүйн орчин дахь шинэ зохицуулалтууд, хэрэглэхэд анхаарах асуудал", "Шүүхийг үл хүндэтгэх зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа", "Үр дүнтэй цахим сургалт зохион байгуулах нь", "Кибер орчныг ашиглаж үйлдэгддэг хүн худалдаалах гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдвээр сургалтын хөтөлбөр боловсруулах саналыг хэлэлцэн, нийт гишүүд хөтөлбөр боловсруулахыг дэмжсэн юм.



### "ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭДТЭЙ СЭТГЭЦИЙН ГЭМТЭЛД СУУРИЛСАН АРГАЧЛАЛААР АЖИЛЛАХ НЬ" СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



"Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэдтэй сэтгэцийн гэмтэлд суурилсан аргачлалаар ажиллах нь" сэдэвт сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Сургалтад "Хөөрхөн Зүрх" ТББ-ын сэтгэл зүйч П.Энхчимэг Сэтгэцийн гэмтлийн тухай ерөнхий ойлголт сэдвээр хичээл заасан бол тус байгууллагын сэтгэл зүйч Г.Түвшинжаргал Хүн худалдаалах гэмт хэрэг ба хохирогч даван туулагчид илрэх сэтгэцийн гэмтлийн нийтлэг шинж тэмдэг; Хохирогч даван туулагчтай сэтгэцийн гэмтэлд суурилсан зарчмаар ажиллах нь зэрэг сэдвээр хичээл удирдан явуулав. Харин Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Н.Одонтуул "Хүн худалдаалах болон бэлгийн мөлжлэгийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулахад шүүгчийн анхаарах асуудал" сэдвээр хичээл заасан юм.

### АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ҮНДЭСНИЙ ШҮҮХИЙН КОЛЛЕЖТОЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал Д.Эрдэнэчимэг, Улсын дээд шүүхийн шүүгч, Эрүүгийн хэргийн танхимиын тэргүүн Ч.Хосбаяр, Улсын дээд шүүхийн шүүгч Н.Баярмаа нар Америкийн Нэгдсэн Улсын Үндэсний шүүхийн коллежийн Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Бенес З.Алданаг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Америкийн Нэгдсэн Улсын Үндэсний шүүхийн коллежтой харилцан ойлголцлын санамж бичиг байгууллаа. Уулзалтаар хоёр байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны тухай харилцан ярилцаж, хамтран хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ болон хамтын ажиллагааны хүрээг хэрхэн өргөжүүлэх боломж нөхцөлийн талаар санал солилцлоо.



## ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ БОЛОН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Захиргааны хэргийн давж заалдах болон анхан шатны шүүхийн шүүгчдэд зориулсан мэргэшүүлэх сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд зохион байгууллаа. "Ашигт малтмалын талбайг төрийн болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авсантай холбоотой нөхөх олговор олгуулах маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудал", "Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдлийг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбоотой захиргааны үйл ажиллагааны маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудал", "Ашигт малтмалын болон газрын эрх зүйн харилцааны хүрээнд гарч буй маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудал", "Түгээмэл тархацтай ашигт малтмалын маргаан шийдвэрлэхэд анхаарах асуудал", "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотлох үүрэг, нотлох үүргийн хуваарилалт" зэрэг сэдэвт сургалтад нийт 75 шүүгч танхимаар хамрагдлаа.



## ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО



Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулагданы 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлыг 05 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа.

Эрдэм шинжилгээний хурлыг нээж, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн Д.Мөнхтуяа үг хэлэв. Тэрбээр "Шүүхийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, нийгэмд шударга ёсыг бэхжүүлэхэд чиглэгддэг бол үүнийг бие даасан шүүхийн тогтолцоо, хараат бус, зохих ёсоор бэлтгэгдсэн чадварлаг шүүгч, хувь хүний хүчин зүйлээс

салгаж ойлгох аргагүй юм. Захиргааны хэргийн шүүгчдийг мэргэшүүлэх үе шаттай тогтмол сургалтыг зөв агуулга хэлбэрээр оновчтой тогтоож, зохион байгуулахад гүнзгий анхаарч, Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй хамтран ажиллаж ирлээ. Шүүгч хүний өөртөө цогцлоосон мэдлэг чадвар, өндөр ёс зүйн хослол бол жинхэнэ үнэт зүйл бөгөөд эрдэм мэдлэгийн хүч чадал нь хүний өөртөө итгэх итгэл, дотоод ухамсрыг сэргээж, өөр бусдаас хараат бусаар оршин тогтнох бодит тулгуур болно гэлээ.

## ШҮҮГЧ-СУДЛААЧИД ТАЙЛАНГАА ХЭЛЭЛЦҮҮЛЛЭЭ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2024 оны 01 дүгээр сараас эхлэн шүүгч-судлаачаар ажилласан Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ш.Оюунханд, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэл нар 06 дугаар сарын 25-ны өдөр тайлангаа хэлэлцүүллээ. Шүүгч Ш.Оюунханд "Шүүхийн практик" (ШП) систем, түүний хөгжүүлэлтийн явцын талаар танилцуулав.. Мөн Шүүгч А.Сарангэрэл тайлангаа цахимаар хэлэлцүүлж, шүүгч-судлаачаар ажиллаж байх хугацаандаа "Иргэн хуулийн этгээдийн шүүхэд хандах эрхийг Захиргааны хэргийн шүүхээс хэрэгжүүлж буй байдал, түүнд тулгамдаж буй асуудал" сэдвээр судалгааны ажил хийж гүйцэтгэсэн юм.





## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

Дугаар/14/

### АНУ-ЫН "НЭЭЛТТЭЙ ДЭЛХИЙ" ХӨТӨЛБӨРТ АМЖИЛТТАЙ ХАМРАГДЛАА

АНУ-ын Конгрессын дэргэдэх Олон улсын манлайллын төвөөс жил бүр хэрэгжүүлдэг "Нээлттэй дэлхий" хөтөлбөр 2024 оны 6 дугаар сарын 12-22-ны өдрүүдэд АНУ-ын Вашингтон ДС, Техас мужийн Плэйнвью хотуудад зохион байгуулагдаж, Шүүхийн академийн Захиргааны эрх зүйн секторын эрхлэгч С.Цэрэндолгор, Баян-Өлгий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч С.Өмнөрбек, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Г.Мөнхтулга, Төв аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Мөнхбүрэн, Дархан-Уул аймаг дахь анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Э.Амарсанаа нар оролцлоо.



### МОНГОЛ УЛСЫН ШҮҮГЧИД БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСАД СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Шүүхийн Академийн шүүгч-сургагч багш нар удирдан явууллаа.

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Бүгд Найрамдах Турк Улсын Шүүхийн Академитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсны хүрээнд хэрэгжиж буй 2 дахь удаагийн сургалтад Монгол Улсаас нийт 28 шүүгч 2024 оны 06 дугаар сарын 09-13-ны өдрүүдэд Бүгд найрамдах Турк Улсын Истанбул хотод айлчилж, кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын сургалтад хамрагдлаа. Тус сургалтыг "Олон улсын хууль тогтоомжийн хүрээнд кибер гэмт хэрэгтэй тэмцэх", "Өнөөгийн кибер гэмт хэрэг, мэдээллийн системийн аюулгүй байдал", "Цахим нотлох баримт ба цахим гэмт хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа", "Гэмт хэргийн улмаас олсон орлогыг угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх" зэрэг дэд сэдвийн хүрээнд тус улсын шүүгч, прокурор,



### МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ СЭТГҮҮЛИЙН 108 ДАХ ДУГААР ХЭВЛЭГДЛЭЭ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний улирал тутмын "Монголын төр, эрх зүй" сэтгүүлийн 108 дах буюу 2024 оны 2-р улирлын тусгай дугаар хэвлэгдэн гарлаа. Энэ улирлын тусгай дугаарт бүх шатны захиргааны хэргийн шүүхийн шүүгч нар болон Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс Монгол Улсад захиргааны хэргийн шүүх байгуулагсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний өгүүллүүд нийтлэгдсэнээрээ онцлог байв.



### ШҮҮХИЙН АКАДЕМИЙН АЛБАН ХААГЧИД ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШҮҮХЭЭР ЗОЧИЛЛОО

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг тэргүүтэй академийн албан хаагчид 2024 оны 07 сарын 01-ны өдөр Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны болон Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр зочилж, шүүхийн үйл ажиллагаатай танилцлаа. Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг уулзалтын үеэр шүүн таслах ажиллагаа хэрхэн хэрэгжиж буйг практикт суурилсан мэдээ мэдээллээр дамжуулан хүргэсэнд талархал илэрхийлж, цаашид хамтран хэрэгжүүлж болох хөтөлбөр арга хэмжээний талаар санал солилцов.



## МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

Дугаар/14/

### АНУ-ЫН КОНГРЕССЫН ДЭРГЭДЭХ “ОЛОН УЛСЫН МАНЛАЙЛАЛ” ТӨВИЙН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр АНУ-ын конгрессын дэргэдэх “Олон Улсын манлайлал” төвийн гүйцэтгэх захирал Жэйн Саргус, тус төвийн дэд захирал Маура Шелден, АНУ-ын Элчин сайдын яамны Улс төрийн мэргэжилтэн М.Номинцэцэг болон Олон нийттэй харилцах албаны төгсөгч, мэргэжилтний хөтөлбөр хариуцсан ажилтан Б.Цэрэндагва нарыг хүлээн авч уулзлаа. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл, АНУ-ын Конгрессын дэргэдэх “Нээлттэй дэлхий манлайлал” төвийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд АНУ-ын шүүхийн үйл ажиллагаа, шүүхийн бие даасан, хараат бус байдлыг хэрхэн хангаж буй сайн туршлагатай танилцах хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш Монгаас нийт 70 гаруй оролцогч тус хөтөлбөрт хамрагджээ.



### ОЮУНЫ ӨМЧИЙН АЛСЫН ЗАЙН СУРГАЛТЫН ЯВЦЫН УУЛЗАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ



Шүүхийн академи Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагатай хамtran ажиллах гэрээний хүрээнд зохион байгуулсан нийт 8 долоо хоногийн хугацаанд үргэлжилсэн оюуны өмчийн алсын зайн сургалтын явцын уулзалтыг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр танхимаар зохион байгууллаа. Оюуны өмчийн алсын зайн сургалтад Монгол Улсаас нийт 146 шүүгч хамрагдсан бөгөөд найман модуль бүхий цуврал хичээлийг шат дараатай судлан, Сургалтыг “Шүүгчийн цахим сургалтын систем”-ээр дамжуулан албан ёсны эрхтэйгээр шүүгчдэд хүргэсэн бөгөөд Ханис-Зайделийн сан дэмжин ажилласан юм.

### МЕНТОРШИП ХӨТӨЛБӨРИЙН ХААЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛЛОО



Шүүхийн академийн бие даан хэрэгжүүлж буй өхний удаагийн “Менторшип-2024” хөтөлбөр 6 сарын хугацаанд амжилтай хэрэгжиж, 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хаалтын үйл ажиллагаагаа цахимаар зохион байгууллаа. Залуу шүүгчийн мэргэжлийн ур чадвар, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор хэрэгждэг тус хөтөлбөрт 2024 онд нийт 6 ментор шүүгч чиглүүлэгчээр ажиллаж, 11 менти шүүгч хамрагдсан юм.

### “ШҮҮГЧ-СУДЛААЧ: СУДАЛГААНЫ АЖЛЫН ЭМХЭТГЭЛ”-ИЙН ЦУВРАЛ-2 ХЭВЛЭГДЛЭЭ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 2021 оны нэмэлт өөрчлөлтийн хүрээнд шүүгч нар судлаачаар ажиллах эрх зүйн орчин бүрдэж, 2023 оноос эхлэн шүүгчийг зургаан сар хүртэл хугацаагаар судлаачаар ажиллуулж эхэлсэн бөгөөд энэ онд шүүгч-судлаачаар ажилласан шүүгч нарын хийж гүйцэтгэсэн судалгааны бүтээлийг олон нийтэд түгээх, судалгааны эргэлтэд оруулах зорилгоор “Шүүгч-судлаач: Судалгааны ажлын эмхэтгэл (2024 он, Цуврал 2)” хэвлэгдэн гарлаа. Шүүгч нар “Шүүгч-судлаач: Судалгааны ажлын эмхэтгэл” хоёр дахь цувралыг тус Академийн “Цахим Сургалтын Систем”-д байрлах “Цахим номын сан”-гийн “Бусад судалгаа” хэсгээс үзэх боломжтой.

